

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, “ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ
ӨГӨХ ТУХАЙ”, “МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ
БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ,
ДҮГНЭЛТ**

2024 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороонд тус тус шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат хуулиар зохицуулагдсан Үндэсний зөвлөлийн гишүүнд урамшуулал олгох асуудлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хасах нь хэр зохистой талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара зарим төрийн байгууллагууд болон сургуулийг нүүлгэх зардлын талаар, нийгмийн халамж, тэтгэмжийг оновчтой хуваарилах талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй 5 саналын томъёоллыг гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.6 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Л.ЭНХНАСАН

Хянасан:

Байнгын хороодын ажлын
албаны дарга бөгөөд Ахлах зөвлөх



Б.Хатантуул

Хянасан:

Нийгмийн бодлогын байнгын
хороо хариуцсан Ахлах зөвлөх



Х.Энэбиш

Боловсруулсан:

Нийгмийн бодлогын байнгын
хороо хариуцсан референт



Б.Цогзолбаяр

2024.12.09

**НЭГ.МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 4 дүгээр зүйлийг “Энэ хуулийн батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан

**ХОЁР.МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН “ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа

**ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН “МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх.

6/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах,

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар,
Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун**

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмэх.

7/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар,
Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун**

---o0o---

УИХ-ын гишүүн-ны

зарчмын зөрөөтэй саналын томъёоллын хуудас

Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл.

Санал хураалгах болсон үндэслэл

Нийгмийн даатгалын ерөнхий хууль 35.16, 35.17, 35.19, 35.20, 35.21 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹⁶ дэх хэсгийг зөрчиж байна.

Саналын томъёолол

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг хасах
Үндэсний зохирол, янхий өмчлөлтийн хууль дээр
заалсангүй бол гэж нэмж.

Гарын үсэг /Санал гаргасан УИХ-ын гишүүн/

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг

2024. 12.09

Санал хураалгасан сар, өдөр,

цаг: 2024. 12.09 11:40

Зөвшөөрсөн
САН

С. Зундарт, О. Бронгуун, В. Агдурбал, Н. Чимбураг
ТӨСЛИЙН ТАЛААР ГАРГАСАН
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛЛЫН ХУУДАС

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

Монгол Улсын 2015 оны төслийн тухай хуулийн
дагаж батлагдах УИХ-ын тогтоолд

2. Санал хураалгах болсон үндэслэл:

Төр бүл, хөдөлмөр, иймгэмийн хангааны
салбарын хороонго оруулах, санхүүгийн
эрх биегх болон ураншүүлсвэг
төдөрхэй болгох.

Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4
дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу
үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал
хураалгахгүй.

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

1.6 Төр бүл, хөдөлмөр, иймгэмийн хангааны
салбарын харьцаа газар, байгууллагаудын
хөдсөн үйл ажиллагааг хангахад
шаардлагатай техник, тоног төхөөрөм-
ийг санхүүгийн түрээсийн заргмаар ханга-
хрийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох

Гарын үсэг: Санал гаргасан Улсын Их
Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг/

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 39.14-т "...төслийг
яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад
тохиолдолд холбогдох Байнгын хороонд хуулийн
төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-
оос доошгүй өдрийн өмнө саналаа бичгээр
урьдчилан ирүүлсэн байна.

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

Зөвшөөрсөн /тоо, хувь/:

С. Зурхор, О.Орочсүрэн, С.Цэдэрбат, Н.Амгалан
ТӨСЛИЙН ТАЛААР ГАРГАСАН
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛЛЫН ХУУДАС

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

Монгол Улсын 10х15 омы төсвийн тухай
хуулийг дагаж батлагдах тухайн тогтоолууд.

2. Санал хураалгах болсон үндэслэл:

Тэр бүч, хөдөлмөр, шийтгэлийн
хангаарлын салбарын хөрөнгө,
санхүүгийн эрх олгох болох урамшууллын
тадорхой болгох.

Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4
дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу
үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал
хураалгахгүй.

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

15 Тэр бүч, хөдөлмөр, шийтгэлийн
хангаарлын салбарын хөрвөх шийнээр
баригдах хөрөнгө батлагдахгүй нэг
маардлагатай зарим газар, байгууллагуудад
түрээсийн баримга амьсгалж, ариг ажиллагаа
звүүлэх

Гарын үсэг: /санал гаргасан Улсын Их
Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг/

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 39.14-т "...төслийг
яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад
тохиолдолд холбогдох Байнгын хороонд хуулийн
төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-
оос доошгүй өдрийн өмнө саналаа бичгээр
урьдчилан ирүүлсэн байна.

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

Зөвшөөрсөн /тоо, хувь/:

Нийгмийн бодлогын байнгын хороонд

2024.12.09

12.00 цаг

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна. Үүнд:

1. Уг хуулийн төслийн 4 дүгээр зүйлд " Энэ хуулийн батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө" гэсэн заалтыг "2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө" гэж өөрчлөх.

Үндэслэл: 2025 оны төсвийг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн өөрчлөлт

Зарчмын зөрүүтэй санал гаргасан: УИХ-ын гишүүн



Д.Үүрийнтуяа

АУБХ-ын газар

УИХ-ын гишүүн Д. Чирмийтбаян-ны

зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуудас

Саналыг төслийн ямар зүйл, хэсэг,
заалтын талаар гаргаж байгаа

Санал гаргасан сар, өдөр, цаг
2024.12.09 13.4

ЗГТГ гишүүн өгөх тухай
МУБХ-н татгалзсан

Саналын томъёолол Төрийн 1-р бүсийн 3 дахь хэргийн дараахь

байрлалд оогдох тухай:
"Хүний төрийн хөгжилд оогдох асуудалд хүний нь тус болж
тогтохгүй нь. Төрийн хөгжилд нь. Төрийн хөгжилд нь,
Хүний төрийн хөгжилд нь хүний төрийн хөгжилд нь,
оогдох асуудалд тогтохгүй тусгайлан төрийн хөгжилд нь,
нь 2025 онд үргэлжилж, тогтохгүй тусгайлан төрийн хөгжилд нь,

Санал хураасан сар, өдөр, цаг

Зөвшөөрсөн

Татгалзсан

2025 онд үргэлж тогтох тусгайлан бүр байрлалд байгуулан-
гийн ашиг нь тогтохгүй, хүний төрийн хөгжилд нь
зөв хөгжилд нь, тогтохгүй тусгайлан төрийн хөгжилд нь,
хүний төрийн хөгжилд нь хүний төрийн хөгжилд нь
байрлалд хүний төрийн хөгжилд нь байрлалд
хүний төрийн хөгжилд нь хүний төрийн хөгжилд нь
зөв хөгжилд нь, үр дүнд нь 2025 онд хүний
хөгжилд нь байрлалд нь УИХ-д татгалзсан."

Санал гаргасан. Д. Чирмийтбаян